



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 11 дугаар сарын 13

Дугаар 03/02

Баян-Өндөр сум

**Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орхон аймаг Баян-Өндөр сумын Их залуу багийн нутаг дэвсгэр орчмын 40.8 га талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг газар чөлөөлж, инженерийн дэд бүтэц байгуулах, нийгмийн дэд бүтэц байгуулах, орон сууцжуулах гэсэн дарааллаар үе шаттай хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ